

БНМАУ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЯАМНЫ  
САЙДЫН ТУШААЛ, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1988 оны 4 дугаар сарын 18 ны өдөр

Дугаар 63/98

Улаанбаатар хот

Богд уулын хамгаалалтыг сайжруулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Тох. д. 1991. 02/01

"Богд уулын хамгаалалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 35 дугаар тогтоол, Сайд нарын Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1988 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 9 дүгээр протоколын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор БНМАУ-ын Байгаль орчныг хамгаалах яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. Дархан цаазтай Богд уулын хамгаалалтын захиргааг Улаанбаатар хотын Байгаль, орчныг хамгаалах газарт байгуулж, захиргааны дүрмийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. "Богд уулын хамгаалалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, Богд уулын зарим амуудыг хамгаалж, ожуулахад туслах байгууллагуудын хуваарийг 3 дугаар хавсралтаар баталсугай.

3. Дархан уулын хамгаалалт болон хүүхэд чирэгжүүлэх, сувиллын зориулалтаар 4 дүгээр хавсралтад заасан барилга байгууламжийг албан байгууллагуудтай тохиролцсон үндсэн дээр үлдээж ашиглах нь зүйтэй гэж үзсүгэй.

4. Богд уулын Шажин хурах, Чулуут, Хүрхэрээ, Туул зерлег, Баянзүрх, Арцат амны зуслан, айл өрхийг 1988 онд, бусад амууд дахь зусланыг 1989 онд сагтаан /5 дугаар хавсралт/ нүүлгэж, газрыг чөлөөлүүлэхийг хотын Байгаль, орчныг хамгаалах газар /н. Дагвадорж/, хотын Архитектур төлөвлөлтийн газар /н. Жадамба/, Ажилчин, Набрамдал, Налайхын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа, холбогдох байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

5. Богд уулын дархан хилийн дотроос нүүлгэн шилжүүлэх албан байгууллага, туслах аж ахуй, өвөлжөөний жагсаалтыг 6 дугаар хавсралтаар баталсугай.

6. Богд уулын зарим амуудын алба, амины зусланыг нүүлгэхтэй холбогдуулан гэрэл, ус, цахилгаан, тээвэр, худалдааны үйлчилгээг Шажин хурах, Чулуут, Хүрхэрээ, Баянзүрх, Туул зерлег, Арцатны зусланд 1988 оноос, бусад зусланд 1989 оноос зогсоосугай.



7. Богд уулын амуудад зуслангийн эдэлбэрт ашиглагдаж байсан талбайг тухайн албан байгууллагын хүчээр 1983-1989 онд багтаан цэвэрлүүлж зүлэгжүүлэх, мод тарих зэргээр нөхөн сэргээх арга хэмжээг авахуулахыг хотын Байгаль орчныг хамгаалах газар /н.Дагвадорж/, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

8. Улаанбаатар хотын Архитектур төлөвлөлтийн газар /н.Кадамбаа/-д даалгах нь:

а. Богд уулын амуудад зуслантай байсан байгууллагууд шинээр зуслан барих зөвшөөрлийг зохих журмаар авсан тохиолдолд зуслангийн барилга байгууламж барих газрын асуудлыг саадгүй шийдвэрлэж өгсүгэй.

б. Богд уулын байгаль хамгаалагч нарын байнга оршин суух цэгийг тогтоож, нэг загварын орон сууц, туслах аж ахуйн хэсгийн зураг төсвийг 1988 оны сүүлийн хагаст багтаан гаргаж өгсүгэй.

9. 1988 онд багтаан Богд уулын хамгаалалтын захиргааны ажилтнууд, байгаль хамгаалагч нарын албан ахуйн хэрэгцээнд шаардагдах авто машин, мод, зөврийн радио станц, буу, дуран, магнитофон, фото аппарат зэрэг хяналт балгалт, сурталчилгааны хэрэгслэлээр хангах, 1989-1990 онд багтаан нийт байгаль хамгаалагчдад нэг загварын сууц барих хөрөнгийг гаргаж өгөхийг Байгаль орчныг хамгаалах яамны хөрөнгө оруулалт, хангамжийн хэлтэс /н.Мамоал/-д даалгасугай.

10. Богд уулын байгаль хамгаалагч нарт явуулын ахуй үйлчилгээ, худалдаагаар сард 2-оос доошгүй удаа үйлчилж байхыг хотын Ахуй үйлчилгээний удирдах газар /н.Надмид/, хувсний бараа худалдааны нэгдэл /н.Бадарч/-д даалгасугай.

11. Хотын байгаль орчныг хамгаалах газар /н.Дагвадорж/-д даалгах нь:

а. Богд уулын байгаль хамгаалагч нарын байршлыг оновчтой тогтоож, мэргэжлийн хүмүүсээр хангах зохион байгуулалтын арга хэмжээг авсугай.

б. Байгаль хамгаалагч, хэсгийн эргүүлийн маршрут сүлжээг шинэчилж, газраас тавих гүйцэтгэлийн хяналт шалгалтыг эрчимжүүлсүгэй.

в. Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагуудтай гэрээ байгуулж Богд уулын хөрс, ургамал, усны эх булаг, ой, ан амьтадыг хамгаалах нөхөн сэргээх ойрын ба хэтийн төлөвлөгөө боловсруулж мөрдөн ажилласугай.

г. Богд уулнаас гаргах зуслангуудад ашиглагдаж байсан талбайг цэвэрлүүлэх нөхөн сэргээх ажилд сайнгын хяналт тавьж актаар хүлээн авч байсугай.

д. Богд уулын зарим аманд үлдэх тусгай объектууд, хил орчмын үйлдвэр, албан байгууллагын үйл ажиллагааны горимыг 1988 оны 3 дугаар сард багтаан боловсруулж, баталж мөрдүүлсүгэй.

12. Хариуцуулсан нутаг дэвсгэрт гал түймрийн аюултай үед эргүүл, пост гаргаж 1988-1990 онд багтаан 3 дугаар хавсралтад заасан модыг тарьж, арчлан ургуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг уулын ам хариуцсан байгууллагын дарга, өрхлөгч нарт даалгасугай.



БНМАУ-ЫН БАМГААХ ОРЧНЫ  
ХАМГААГАХ ЯАМНЫ САЙД

У.МАВЛЕТ

*Handwritten signature in blue ink, likely belonging to U. Mavlet.*



Улаанбаатар хотын Алх-ын  
ХАМГААГАХ ЯАМНЫ САЙД

СОНХЖАГТАЛ

*Handwritten signature in blue ink, likely belonging to Sonkhagtal.*



БНМАУ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЯАМНЫ  
САЙДЫН ТУШААЛ, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1988 оны 4 дугаар сарын 18 ны өдөр

Дугаар 63/98

Улаанбаатар хот

Богд уулын хамгаалалтыг сайжруулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Тох. д. 1991. 02/01

"Богд уулын хамгаалалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 35 дугаар тогтоол, Сайд нарын Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1988 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 9 дүгээр протоколын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор БНМАУ-ын Байгаль орчныг хамгаалах яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. Дархан цаазтай Богд уулын хамгаалалтын захиргааг Улаанбаатар хотын Байгаль, орчныг хамгаалах газарт байгуулж, захиргааны дүрмийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. "Богд уулын хамгаалалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, Богд уулын зарим амуудыг хамгаалж, ожуулахад туслах байгууллагуудын хуваарийг 3 дугаар хавсралтаар баталсугай.

3. Дархан уулын хамгаалалт болон хүүхэд чирэгжүүлэх, сувиллын зориулалтаар 4 дүгээр хавсралтад заасан барилга байгууламжийг албан байгууллагуудтай тохиролцсон үндсэн дээр үлдээж ашиглах нь зүйтэй гэж үзсүгэй.

4. Богд уулын Шажин хурах, Чулуут, Хүрхэрээ, Туул зерлег, Баянзүрх, Арцат амны зуслан, айл өрхийг 1988 онд, бусад амууд дахь зусланыг 1989 онд сагтаан /5 дугаар хавсралт/ нүүлгэж, газрыг чөлөөлүүлэхийг хотын Байгаль, орчныг хамгаалах газар /н. Дагвадорж/, хотын Архитектур төлөвлөлтийн газар /н. Жадамба/, Ажилчин, Набрамдал, Налайхын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа, холбогдох байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

5. Богд уулын дархан хилийн дотроос нүүлгэн шилжүүлэх албан байгууллага, туслах аж ахуй, өвөлжөөний жагсаалтыг 6 дугаар хавсралтаар баталсугай.

6. Богд уулын зарим амуудын алба, амины зусланыг нүүлгэхтэй холбогдуулан гэрэл, ус, цахилгаан, тээвэр, худалдааны үйлчилгээг Шажин хурах, Чулуут, Хүрхэрээ, Баянзүрх, Туул зерлег, Арцатны зусланд 1988 оноос, бусад зусланд 1989 оноос зогсоосугай.



7. Богд уулын амуудад зуслангийн эдэлбэрт ашиглагдаж байсан талбайг тухайн албан байгууллагын хүчээр 1983-1989 онд багтаан цэвэрлүүлж зүлэгжүүлэх, мод тарих зэргээр нөхөн сэргээх арга хэмжээг авахуулахыг хотын Байгаль орчныг хамгаалах газар /н.Дагвадорж/, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

8. Улаанбаатар хотын Архитектур төлөвлөлтийн газар /н.Кадамбаа/-д даалгах нь:

а. Богд уулын амуудад зуслантай байсан байгууллагууд шинээр зуслан барих зөвшөөрлийг зохих журмаар авсан тохиолдолд зуслангийн барилга байгууламж барих газрын асуудлыг саадгүй шийдвэрлэж өгсүгэй.

б. Богд уулын байгаль хамгаалагч нарын байнга оршин суух цэгийг тогтоож, нэг загварын орон сууц, туслах аж ахуйн хэсгийн зураг төсвийг 1988 оны суулийн хагаст багтаан гаргаж өгсүгэй.

9. 1988 онд багтаан Богд уулын хамгаалалтын захиргааны ажилтнууд, байгаль хамгаалагч нарын албан ахуйн хэрэгцээнд шаардагдах авто машин, мод, зөврийн радио станц, буу, дуран, магнитофон, фото аппарат зэрэг хяналт балгалт, сурталчилгааны хэрэгслэлээр хангах, 1989-1990 онд багтаан нийт байгаль хамгаалагчдад нэг загварын сууц барих хөрөнгийг гаргаж өгөхийг Байгаль орчныг хамгаалах яамны хөрөнгө оруулалт, хангамжийн хэлтэс /н.Мамсал/-д даалгасугай.

10. Богд уулын байгаль хамгаалагч нарт явуулын ахуй үйлчилгээ, худалдаагаар сард 2-оос доошгүй удаа үйлчилж байхыг хотын Ахуй үйлчилгээний удирдах газар /н.Надмид/, хувсний бараа худалдааны нэгдэл /н.Бадарч/-д даалгасугай.

11. Хотын байгаль орчныг хамгаалах газар /н.Дагвадорж/-д даалгах нь:

а. Богд уулын байгаль хамгаалагч нарын байршлыг оновчтой тогтоож, мэргэжлийн хүмүүсээр хангах зохион байгуулалтын арга хэмжээг авсугай.

б. Байгаль хамгаалагч, хэсгийн эргүүлийн маршрут сүлжээг шинэчилж, газраас тавих гүйцэтгэлийн хяналт шалгалтыг эрчимжүүлсүгэй.

в. Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагуудтай гэрээ байгуулж Богд уулын хөрс, ургамал, усны эх булаг, ой, ан амьтадыг хамгаалах нөхөн сэргээх ойрын ба хэтийн төлөвлөгөө боловсруулж мөрдөн ажилласугай.

г. Богд уулнаас гаргах зуслангуудад ашиглагдаж байсан талбайг цэвэрлүүлэх нөхөн сэргээх ажилд оамын хяналт тавьж актаар хүлээн авч байсугай.

д. Богд уулын зарим аманд үлдэх тусгай объектууд, хил орчмын үйлдвэр, албан байгууллагын үйл ажиллагааны горимыг 1988 оны 3 дугаар сард багтаан боловсруулж, баталж мөрдүүлсүгэй.

12. Хариуцуулсан нутаг дэвсгэрт гал түймрийн аюултай үед эргүүл, пост гаргаж 1988-1990 онд багтаан 3 дугаар хавсралтад заасан модыг тарьж, арчлан ургуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг уулын ам хариуцсан байгууллагын дарга, өрхлөгч нарт даалгасугай.



БНМАУ-ЫН БАМГААХ ОРЧНЫ  
ХАМГААГАХ ЯАМНЫ САЙД

У.МАВЛЕТ

*Handwritten signature in blue ink, likely belonging to U. Mavlet.*



Улаанбаатар хотын Алх-ын  
ХАМГААГАХ ЯАМНЫ САЙД

СОНХЖАГТАЛ

*Handwritten signature in blue ink, likely belonging to Sonkhagtal.*